

ШИНЭЭР ТӨВЛӨРСӨН ДУЛААНД БАРИЛГА ОБЪЕКТ ХОЛБОХОД

ШААРДАГДАХ МАТЕРИАЛ

Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд мөрдөх холболтын журмыг үндэслэн шинэ барилга объектыг дулаанд холбоно.

Холболтын зөвшөөрөл авахдаа дараах материалыг бүрдүүлнэ:

1. Компани – Албан тоот, Иргэн – Өргөдөл / шинээр дулаанд холбогдох тухай /
2. Техникийн нөхцлийн хуулбар.
3. Манай байгууллагаар болон “Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар”-т зөвшөөрч хянагдсан, Гадна дулаан-ГД, Дулаан Механик-ДМ, Халаалт салхивч-ХС-ын зураг төслийг техникийн нөхцлийн даалгаварын дагуу мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компаниар хийлгэж баталгаажуулсан байна. Мөн Барилга архитектур-БА-ын зураг батлагдсан байна.
4. Зургийн дагуу зуны график зогсолттой уялдаж огтолгоо хийсэн байх.
5. Тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гадна дулаан, дотор систем, дулааны зангилаа болон узель угсруулж шахалт угаалтыг хийж тус бүрд нь акт үйлдсэн байх. */ББ-1, М-23, М-15 маягт/*
6. “Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар”-ын мэдээллийн санд гадна дулааны шугамыг бүртгүүлж CD хэлбэрээр.
7. Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барихаар техникийн нөхцөл хүссэн иргэн, албан байгууллага нь эрчим хүчний дэд станц болон шугам тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх нөхцөл хангасан байх.
8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниар Стандартын шаардлага хангасан тоолуур суурилуулсан акт, бичиг баримтыг бүрдүүлсэн байх.

Жич: Гадна агаарын хэм хүйтэрч төвлөрсөн дулаан хангамжийн горим ажиллагааны онцлогоос хамаарч Эрчим хүчний сайдын тушаалын дагуу 11 дүгээр сарын 01 нээс 03 дугаар сарын 01 -ны хооронд шинэ барилгын холболтыг зогсоодог тул техникийн нөхцөл болон шинэ барилгын холболтын материалыг түр хугацаагаар хязгаарладаг болно.